



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



Хөгжлийн бэрхшээлтэй
иргэдийн бизнес Инкубатор төв

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЦАХИМ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

(Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний
нийгмийн байгууллагуудын сургагч багш нарт зориулав.)

Улаанбаатар хот

2021.06.16

БАТЛАВ:

СЗСҮТ-ийн Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн захирал:



/Б.Алтмаа /

Хөтөлбөрийг хянасан:

Ажлын хэсгийн дарга Б.Амаржаргал /ХБХХЕГ-ын Хөгжил, нийгмийн оролцооны газрын дарга/

Ажлын хэсгийн дэд дарга Б.Алтмаа /СЗСҮТ-ийн Мэргэжлийн боловсрол, Ур чадвар олгох сургуулийн захирал/

Хөтөлбөрийн зөвлөх:

Х.Сансармаа /ХБХХЕГ-ын ХНОГ-ын Хөгжлийн бэрхшээлийн судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн/

Б.Гүнжилмаа /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төвийн захирал/

Санал өгсөн:

Л.Отгон /СЗСҮТ-ийн Хэвлэл, график, дизайны мэргэжлийн багш/

Г.Болормаа /Монголын хараагүй хүүхэд залуучуудын холбооны тэргүүн/

Н.Мөнхцэцэг /Чингэлтэй дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн/

С.Наранцэцэг /ХБХ-ий эрхийн үндэсний төвийн тэргүүн/

Я.Алтанзагас /ХБХ-ний ахмадын холбооны тэргүүн/

Я.Авирмэд /Айвуун ТББ-ын захирал/

Б.Чулуундолгор /Тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн/

Хөтөлбөр боловсруулсан:

Г.Осоржалам /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төвийн менежер/

Д.Нандин-Эрдэнэ /ХБХХЕГ-ын мэдээлэл технологи асуудал хариуцсан мэргэжилтэн/

АГУУЛГА

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд цахим сургалт зохион байгуулах арга зүйн сургалтын хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

1.1. Цахим сургалт, түүний хэрэгцээ, шаардлага

1.2. Цахим сургалтын хөтөлбөрийн зорилго, хамрагдах хүрээ, зориулалт

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд цахим сургалт зохион байгуулах сургалтын хөтөлбөр, ашиглах материал

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд цахим сургалт зохион байгуулах багшийг бэлтгэх сургалтын хөтөлбөр

2.2. Цахим сургалтын хөтөлбөрийн сэдвүүд, ашиглах материал

НЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЦАХИМ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Цахим сургалт, түүний хэрэгцээ, шаардлага

Техник, технологийн дэвшилттэй уялдан мэдээллийн арга хэрэгсэл сургалтын процесс шинэчлэгдсэн. 20-р зууны дунд үед уламжлалт сургалт буюу танхимын сургалт зонхилж байсан бол орчин үед электрон буюу цахим сургалт, хосолсон сургалт илүү ашиглагдаж эхэллээ. Сүүлийн жилүүдэд цар тахалтай холбоотойгоор дэлхий даяар цахим уулзалт, сургалтыг их ашиглах болсон. Цахим сургалт гэдэг нь мэдээллийн технологид суурилсан сургалт юм. Цахим сургалтын нь компьютерт суурилсан сургалт, вебд суурилсан сургалт, виртуал сургалт, TV, радиогийн хэрэгсэл ашигласан сургалтын нэг дэвшилтэд хэлбэр юм. Цахим сургалт нь суралцагчдад сургалтын агуулгыг хүргэхдээ бүх төрлийн цахим дамжуулах төхөөрөмж, интернет, хиймэл дагуулын систем, аудио, видео систем, интерактив телевиз, CD – ROM зэргийг ашиглаж байна.

Цахим сургалтын давуу тал нь танхимын сургалтыг бодвол тогтсон нэгж цаг хугацаанд заахгүй тул удаан ойлгодог хүмүүс, хичээлдээ сууж амжаагүй хүмүүст тухайн хичээлийг дахин давтан үзэж, сэргээн үзэх боломжийг олгодог, хичээлийн агуулгыг гэр, сургууль дээрээсээ, компьютер болон гар утаснаасаа үзэх, хичээлд оролцох, ойлгоогүй хичээлээ нөхөж үзэх зэрэг орчинг бүрдүүлсэн байдгаараа онцлог юм. Нөгөө талаас Ковид-19 цар тахлын үед цахим орчинд суралцах хэв маягт шилжиж хөгжиж байгаатай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суралцах үйл явцыг тасалдуулахгүйн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад тохирсон цахим сургалт явуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг цахим сургалтын талаар мэдлэг чадвар олгож, цахимаар сургалт зохион байгуулах заах арга зүйтэй болгосноор тэдэнд чиглэсэн богино болон урт хугацааны сургалтууд үр дүнтэй хүрээмжтэй тасралтгүй явагдах, улмаар бэрхшээлийн ялгаатай байдлаас болж хүртэх, сонсох мэдрэхүйн онцлогт тохируулан сургалтыг зохион байгуулах, зөөлөн дэд бүтцийг хүртээмжтэй болгох ур чадварт суралцаж, сургалтыг илүү үр дүнд хүргэх юм.

Иймд ХБИ-дийн цахим интернэтийн орчинд ажиллах арга зүйг сайжруулах үүднээс Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.2 дах заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.1 дах заалт, 40.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ХБХХЕГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/14 тоот тушаалын дагуу ажлын хэсэг гарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, сурч боловсрох, хөгжих эрхийг тасалдуулахгүйн байх, цахимаар оролцох боломжийг бүрдүүлэхэд дөхөм үзүүлэх үүднээс тэдний нийгэм-сэтгэл зүйн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сургалтыг хүртээмжтэй зохион байгуулахад чиглэгдсэн арга зүйн сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хамтран боловсруулан ажиллаж байна.

1.2. Цахим сургалтын хөтөлбөрийн зорилго, хамрагдах хүрээ, зориулалт

Зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан сургалтыг цахимаар зохион байгуулахад тэдний онцлог, хэрэгцээнд нийцсэн цахим платформ хэрхэн ашиглах мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний харилцаа, ур чадварын талаарх мэдлэг олгох арга зүйн сургалт зохион байгуулах багш нар зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах

Зориулалт:

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан цахим сургалтын агуулгыг зохиох, боловсруулах, ашиглах, цахимаар хэрхэн зохион байгуулах, багшлах арга зүйд суралцах

Хамрах хүрээ, зохион байгуулалт:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан сургалтыг цахимаар зохион байгуулж байгаа сургалтын баг

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах багш нар

- 1 удаагийн сургалтад 10-15 сургагч багш нарыг бэлтгэх

- Боловсруулсан цахим сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулах

- Сургалтаа зохион байгуулахдаа сэдэв тус бүрийн ашиглах материалыг өгөгдсөн заавар, зөвлөмжийн дагуу ашиглах

Арга зүй

ХБХХЕГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/14 тоот тушаалын дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн гарч “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан сургалтыг цахимаар зохион байгуулахад тэдний онцлог, хэрэгцээнд нийцсэн цахим платформ хэрхэн ашиглах мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний харилцаа, ур чадварын талаарх мэдлэг олгох арга зүйн сургалт зохион байгуулах багш нар зориулсан сургалтын хөтөлбөр” боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөтөлбөрийг боловсруулахын тулд ажлын хэсгийн уулзалтыг 1 удаа зохион байгуулж, нэг дэх уулзалтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын төлөөлөлд цахим сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага, хөтөлбөрт тусгах ерөнхий агуулгыг танилцуулсан. Мөн цахим хөтөлбөрийн агуулга, аргачлал, саналыг тусгах саналуудыг авч дахин боловсруулж тус хөтөлбөрийг цахимаар илгээн танилцуулж дахин саналыг аван танилцуулж эцэслэсэн. Цахим хөтөлбөрийн төслийг турших туршилтын сургалтын хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагад цахим хөтөлбөрийг танилцуулж ажилласан болно.

ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЦАХИМ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, АШИГЛАХ МАТЕРИАЛ

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд цахим сургалт зохион байгуулах багшийг бэлтгэх сургалтын хөтөлбөр, агуулга

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЦАХИМ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ БАГШИЙГ БЭЛТГЭХ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

... он ... сар ... өдөр

Зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан сургалтыг цахимаар зохион байгуулахад тэдний онцлог, хэрэгцээнд нийцсэн цахим платформ хэрхэн ашиглах мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний харилцаа, ур чадварын талаарх мэдлэг олгох арга зүйн сургалт зохион байгуулах багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах

Хамрах хүрээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, ААН, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт явуулдаг сургагч багш нар.

Сургалтын хэлбэр: Цахим болон танхим, дадлага ажил

Хүрэх үр дүн: Цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалт, мэдээлэл, зөвлөгөө, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ТББ, ААН нь цахим сургалтын горимд шилжин ХБИ-дэд чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээ тасралтгүй хүртээмжтэй явагдах нөхцөл бололцоо үүсч сургалтын байгууллагууд нэг арга зүйгээр ажиллах боломжтой.

Цаг	Сэдэв	Агуулга, тайлбар, ашиглах материал
1 дэх өдөр		
09.00-09.30	Бүртгэл, оролцогчид танилцах	Багш хэрхэн ямар аргаар танилцахыг өөрөө чөлөөтэй сонгох боломжтой.
09.30-10.00	Танилцах, нээлт	
10.00-10.40	Цахим сургалт гэж юу вэ?, сургалт зохион байгуулах хэрэгцээ, шаардлага, сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн	Сэдэв 1 ашиглах.
10.40-11.20	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм-сэтгэл зүйн онцлог, сургалт зохион байгуулахад анхаарах зүйлс	Сэдэв 2 ашиглах.
11.20-11.30	Цайны завсарлага	
11.30-12.30	Насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний сурах арга барил	Сэдэв 3 ашиглах.
12.30-13.00	Асуулт, хариулт	
2 дох өдөр		
09.00-09.40	Цахим хичээлд тавигдах технологийн шаардлага	Сэдэв 4 ашиглах
09.40-10.20	Цахим сургалтын программууд: Google Zoom ашиглах	Сэдэв 5 ашиглах, багш цахимаар бодитоор үзүүлэн суралцагчид даган дуурайж дадлага хийх хэлбэрээр суралцана.
10.20-11.00	Дадлага ажил	
11.00-11.10	Цайны завсарлага	

11.10-11.50	Google meet, google from текст боловсруулах ашиглан сургалт явуулах	Сэдэв 5 ашиглах., багш цахимаар бодитоор үзүүлэн суралцагчид даган дуурайж дадлага хийх хэлбэрээр суралцана.
11.50-13.00	Дадлага ажил	
3 дах өдөр		
09.00-09.40	Teams програм ашиглан сургалт явуулах	Сэдэв 5 ашиглах, багш цахимаар бодитоор үзүүлэн суралцагчид даган дуурайж дадлага хийх хэлбэрээр суралцана.
09.40-10.20	Дадлага ажил	
10.20-11.00	Вэбинар гэж юу вэ? Сургалтын үед бичлэг хийх	Сэдэв 5 ашиглах., багш цахимаар бодитоор үзүүлэн суралцагчид даган дуурайж дадлага хийх хэлбэрээр суралцана.
11.00-11.10	Цайны завсарлага	
11.00-11.40	Any desk ашиглах заавар ойлголт	Сэдэв 5 ашиглах., багш цахимаар бодитоор үзүүлэн суралцагчид даган дуурайж дадлага хийх хэлбэрээр суралцана.
11.40-12.00	Дадлага ажил	
12.00-12.30	Сургалтын үнэлгээ	Хөтөлбөрийг дагалдаж буй үнэлгээний хуудсыг багш ашиглах, Сургалтыг илүү үнэлэхийг тулд сургалтын явцад гарсан үйл явцыг ашиглан багш үнэлгээний хуудас боловсруулж болно
12.30-13.00	Хичээлийн хаалт, гэрчилгээ олгох, нэрсийн тулгалт	

2.2. Цахим сургалтын хөтөлбөрийн сэдвүүд, ашиглах материал

СЭДЭВ 1. Цахим сургалт, хэрэгцээ, шаардлага

Хичээлийн зорилго: Цахим сургалт гэж юу вэ?, яагаад цахим сургалт зохион байгуулах шаардлагатай вэ?, цахим сургалтын онцлог, давуу тал, хөгжлийн бэрхшээлтэй хүнд цахимаар сургалт явуулах сургалтын хөтөлбөрийн талаарх ерөнхий ойлголт, мэдээллийг олгох

Хичээлийн цаг: 40 минут /академик цагаар 1 цаг/

Арга зүй: Сэдвийн дагуу PowerPoint илтгэл бэлдэж, хичээлийг тайлбарлах, асуулт, хариулт хэлбэрээр тайлбарлаж зохион байгуулна.

Ашиглах материал: PowerPoint илтгэл, лекц 1

Лекц №1

Сургалтын хэрэгцээ, шаардлага:

Цар тахал нь дэлхий нийтэд тархаж Монгол улсад халдвар дэгдсэнтэй холбогдуулан сургалт, мэдээлэл, зөвлөгөө болон олон нийтийн харилцаа цахимжиж байгаатай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг аливаа сургалт, зөвлөгөө, мэдээ мэдээллээс холцруулахгүйн үүднээс тэдний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтуудыг цахим хэлбэрээр явуулах, тэр дундаа ХБИ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, сургалтын байгууллагуудын багш нар авч ашиглах боломжтой байдлаар цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөр нь хоёр агууллагатай байна.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд цахим сургалт явуулах ерөнхий арга зүй, харилцаа ур чадварыг нэмэгдүүлэх
2. Цахим платформ ашиглан сургалт явуулах арга зүй эзэмшүүлэх

Сургалтын зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан аливаа сургалтыг цахимаар зохион байгуулахад чиглэгдсэн цахим платформ хэрхэн ашиглах, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, харилцааны ур чадварын талаарх ойлголт, мэдлэгийг өгөх арга зүйн сургалт зохион байгуулах багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах.

Багшид тавигдах шаардлага:

Сургалт явуулах сургагч багшийн эрхтэй хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх зохих мэдлэгтэй, зөв ойлголт хандлагатай. Сургагч багш нь цахим орчинд ажиллах чадвартай, компьютер техниктэй ажиллаж байсан туршлагатай, ХБИ-ийн ТББ-т ажилладаг бол давуу тал болно.

Цахим сургалт гэж юу вэ?

Хүний нийгмийн хөгжил, технологийн дэвшилтэй уялдан мэдээллийн хэмжээ асар их болж тэр хэрээр сургалтын процесс шинэчилэгдсэн.

20-р зууны дунд үед уламжлалт сургалт буюу нүүр нүүрээ харсан сургалт зонхилж байсан бол орчин үед электрон сургалт, хосолсон сургалт илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна. Цар тахал дэгдсэнтэй холбогдуулан 2020 оны эхээс дэлхий даяар цахим уулзалт, сургалтыг их ашиглах болсон.

Цахим сургалт гэдэг нь технологид суурилсан сургалт гэж тодорхойлж болдог. Цахим сургалт = технологид суурилсан сургалт Цахим сургалтын томъёолол нь компьютерт суурилсан сургалт, Вебд суурилсан сургалт, виртуал сургалт, TV, радиогийн сургалт зэргийг агуулах сургалтын нэг шинэ хэлбэр бөгөөд үйлчилгээний өргөн цар хүрээг агуулсан байдаг. Цахим сургалт нь суралцагчдад агуулгаа хүргэхдээ бүх төрлийн цахим дамжуулах төхөөрөмжүүдийг ашиглаж болно.

1. Интернет
2. Хиймэл дагуулын систем
3. Аудио
4. Видео систем
5. Интерактив телевиз
6. CD – ROM

Цахим сургалт нь олон давуу талтай. Танхимын сургалт нь тогтсон хугацаандаа нэг л удаа заадаг. Энэ нь удаан ойлгодог, мөн янз бүрийн шалтгаанаар хичээлдээ сууж амжаагүй тохиолдолд тухайн хичээлийг ойлгохгүй өнгөрөх нь бий. Тиймээс цахим сургалт нь танхимын учир дутагдалтай талыг нөхөж хичээлийн агуулгыг гэр, сургууль дээрээсээ, компьютер болон гар утаснаасаа үзэх, хичээлд оролцох, багш нар хичээл болон курс зохион явуулах таатай орчинг бүрдүүлсэн байна.

Цахим сургалт гэж юу вэ?



Багшийн дэмжлэгтэй ба дэмжлэггүй сургалт

Эх сурвалж: Харилцаа холбоо мэдээлэл технологи газар 2019, Тоо бичиг үсэгтэн сургалтын хөтөлбөр

Цахим сургалтын хэрэглэгдэхүүн, боловсруулах арга зүй:

1. Төлөвлөгөө боловсруулах (орчин, хэрэглэгдэхүүн, хичээлийн хэлбэр, цахим програм сонгох, слайд, судалгаа.....)
2. Хэрэглэгдэхүүний төлөвлөлт хийх (Слайдын дизайн, оффис програм, схем, слайд харагдах байдал, фото, бичвэр, компьютерын үзүүлэлт, интернетийн хурд, ойлгомжтой байх, зураг, хөдөлгөөнт дүрс, дуу хоолойн өнгө, дэлгэцэд харагдах байдал.....)
3. Мэдээлэл цуглуулах (дуу авиа хавсралт бэлтгэх видео, график, тухай хичээлтэй холбоотой дүрэм журам, суралцагчдын мэдээлэл, бүртгэл.....)
4. Хэрэглэгдэхүүн бэлдэх (материалын слайд өнгө, үсгийн фонд, бичвэрийн хэмжээ +24....., схем, видео, хөдөлгөөнт дүрс, чанга яригч, камер, интернет орчин, оффис програм.....)
5. Шалгах (Хичээлийг нягтлан шалгаж төлөвлөлт бүрэн гүйцэд эсгийг харах)
6. Турших (слайдын харагдах байдал өнгө, бичвэрийн хэмжээ, видео бичлэг чанар тохиргоо, чанга яригч камер ажиллаж байгаа эсэх, интернэтийн хурд болж байгаа эсэх хичээлийг бүрэн туршиж үзэх)

7. Хөгжүүлэх (хичээлийг дахиад яаж хөгжүүлэх болох, шалгах, турших явцад гарсан алдааг залруулан хөгжүүлэх)

Суралцагчдын оролцох хэлбэр

Бие даан судлах, цахим орчинд сурах хэрэглэгдэхүүнийг бэлдэх, орчноо сонгох, шалгалт, сорилт, интернет орчны суурь мэдлэг, компьютер эсвэл Андрейд гар утас ашиглах, сурах орчноо бүрдүүлэх

Сургалтын хүртээмжтэй байдал

Нэг удаагийн сургалтын анги дүүргэлт 10-15 оролцогч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сургалт явуулахад хатуу, зөөлөн дэд бүтцийг анхааран сургалтын орчин, хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн байна.



ТАЙЛБАР:

Цахим сургалтад хамрагдаж буй насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн хэлбэр, тусгай хэрэгцээнд тохируулан сургалтын бэлтгэл ажлаа хангах

Зөөлөн дэд бүтэц: Багш ямар бэрхшээлтэй хүнд хичээл орох гэж байгаагаа урьдчилан мэдэж хичээлдээ: - Хэрэглэгдэхүүнээ сонгох, цахимаар илгээх тараах материал гарын авлага хэлбэр хэмжээ, хичээл заах арга зүй тохиргоо сургалтын явцыг төлөвлөн тохируулахыг зөөлөн дэд бүтэц гэнэ.

Жишээ нь: Хараагүй хүмүүст хичээл ороход оффис програм, дүрс шаардлагагүй. Хоолойн өнгө ярианы хурдыг тааруулахад анхаарах (дундаж хэмнэлээр, чанга ярих, чанга яригч шаардлага хангаж байх) сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан цахим сургалтыг зохион байгуулахдаа дохионы орчуулагчтай байх, орчуулагчийн дүрс нүдэнд тусахуйц, оффис програмын хичээл, үзүүлэх материал ойлгомжтой үг хэллэгтэй байх.Цахимаар суралцагчид хичээлд суух хугацаандаа тодорхой хэмжээгээр тусгаарлах, сурах боломж нөхөцлөө бүрдүүлэхийг зөвлөх, шаардлагатай тохиолдолд гэр бүлийнхээ дэмжлэгийг авахыг зөвлөх

Хатуу дэд бүтэц : Цахимаар сургалт явуулах үед суралцагчид өөрийн тав тухтай сурах нөхөцлөө бүрдүүлэх

Үүнд: Өөрт бэрхшээл учруулахгүй тав тухтай байрлалаа олж суух, интернетийн сүлжээ тасалдахгүй байх, камер, чанга яригч ажиллагаатай байж цахимаар амьд харилцаа үүсгэх.....

Хичээлийн зорилготой уялдуулан зорилгыг хангахуйц арга хэлбэр, жишээг сонгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах арга бэрхшээлийн хэлбэр тус бүр онцлогтой.

Сургалтыг явуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог байдлаар дараах арга аргачлалыг ашиглах боломжтой.

Цахим сургалт явуулахдаа багш зохицуулалт хийн суралцагчдын санал, хүсэлт, асуулт хариултыг ээлж дараалалтайгаар чанга яригчийг зөв хэрэглэх.

Тухайлбал: Мэдээлэл түгээх буюу лекцийн арга

Лекцийн арга нь сэтгэлгээний мэдлэг ойлголтыг хангахад тохиромжтой. Багш мэдлэгээ түгээхдээ бодит жишээ ярих, хамтдаа гарцыг олох оролцооны аргуудтай хослуулах цуглуулсан мэдлэгийг хураангуй хялбарчилсан тайлбараар 10-15 минут хэлэлцүүлэг явуулах, өртөөлөн мэдлэг түгээх зэрэг, суралцагсадтай бодит жишээ ярилцан хамтдаа зөв гарцыг олох зэрэг оролцооны аргуудтай хослуулах.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга: Энэ арга нь маргагч тал, няцаагч тал болж хуваагдан хамтран хэлэлцэх, илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвартай болгох зорилготой.

Жишээ нь: Суралцагчдаас хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөрийн харилцаанд ороход хамгийн чухал бэрхшээлтэй асуудлууд юу болохыг асууж багш уг сэдэвт холбогдолтой хэлэлцүүлгээ эхлэх юм. Хичээлийн явцаас шалтгаалаад эрх зүй, ёс суртахуун, практикийн /тухайн хүний амьдрал, бодит жишээтэй / холбогдолтой асуудлууд гарч болох юм.

Суралцагчид эхлээд авч үзэж буй тохиолдлын хамгийн маргаантай болох гол зүйлийг ойлгох. Багшийн зүгээс суралцагчдын түвшин болон уг аргаар ажиллах, дадлага, туршлага зэргийг харгалзан уг жишээний гол маргаантай хэсгийн ярьх. Багшийн эсвэл суралцагчдын хүчээр тодорхой ойлгож авсан асуудлын гол хэсгийг дараа дараагийн үзэх зүйлээс ялган салгах. Үүний дараа суралцагчид баримт, нотолгоо олох, боловсруулах, гаргасан баримт нотолгоо нь нэг хэсэг нь санааг дэмжих, нөгөө хэсэг эсэргүүцнэ. Энэ тохиолдолд олон талыг хамарсан асуудлуудыг хөндөн ярилцаж болно. Маргагч дэмжих буюу няцаах ямар баримт, шалтгаан байж болох вэ? Аль нь үнэмшил муутай болох, яагаад? Нийгэм болоод маргалдагч талуудын хувьд энэхүү асуудлыг яаж, хэрхэн шийдвэрлэсэн ямар үр дагавар учирч болох, баримт нотолгоо, учир шалтгаан болон шийдвэр бүрийн давуу тал нь юу болох эрх зүйн баримт ашиглах, Үндсэн хууль бусад тогтоомж болон олон улсын гэрээг холбон судалж чадаж байгаа эсэх нотолгоо, баримтын учир шалтгааныг тодруулж хэлэлцэх явцад бусдын нотолгоонд хүлээцтэй хандах хэлэлцүүлгийн ил тод байдлыг хангасан уур амьсгалыг бүрдүүлэх, суралцагчид бусдыг сонсож хүндэтгэн, бодит хандаж, үнэлэлт өгөх чадвартай байна. Энэ үе шатанд бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргахад анхаарлыг төвлөрүүлэх, гарсан шийдвэрийн үндэслэлийг заавал асуух хэрэгтэй. Багш дүрэм журам, мэдлэгийнхээ хүрээнд шийдвэрийг гаргах уншиж сонсгосон бол сурагчдаар үнэлүүлэх хэрэгтэй. Тэд багшийн уншсан сэдэвтэй санал нийлж байна уу, үгүй юу, яагаад шийдвэр уг ажиллагаанд холбогдогч талуудад хэрхэн тусч байна гэх мэтээр асуух нь суралцагчид үнэлэлт, дүгнэлтээ хэлэх боломж бий болно. Шийдвэрийг суралцагчид гаргасан бол

шийдвэрийг гаргах болсон шалтгаан, үндэслэлийг хэрхэн тайлбарлаж байгааг анхаарах. Хэрэв жишээ авсан кейс шүүхээр шийдвэрлэгдсэн бодит кейс байсан бол багш шүүхийн шийдвэрийг хэлж тайлбарлаж өгөх, бусдад тохиолдсон шийдвэрлэгдээгүй кейс бол багш хуулийн хүрээнд тайлбарлан гарцыг нь хэлж өгөх.

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх, сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймд хичээлийг зохион байгуулалт сайтай, үүссэн маргаантай байдлыг хяналттай байлгахад дараах дүрмийг багш баримтлах

- ☞ Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлэх;
- ☞ Цаг барьж, ганцаараа ярих зохицуулалтыг багш чанга яригчийг тохируулах;
- ☞ Уриа хэрэглэхээс зайлсхийх;
- ☞ Маргааныг хийсвэр төвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлаар ярилцах
- ☞ Өөрийн байр суурийн эргэлзээтэй зүйл, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрөх.
- ☞ Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна. Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ДАРААЛАЛ:

- ☞ Багш нэг суралцагчид тодорхой минут өгөх,
- ☞ Чанга яригчийг багш нээж, хаах зохицуулалтыг хийх тухайгаа мэдэгдэх
- ☞ Суралцагчид өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарласнаар багш хамгийн үнэмшилтэй байсныг бүх суралцагчдыг хамруулах үүднээс асууж ярилцах.
- ☞ Багш дүгнэлт гаргах;
- ☞ Маргааныг зогсоож багш суралцагчдын чанга яригчийг хааж дүрэм, журмын дагуу тайлбарыг суралцагчдад өгнө.

Сургалтын материал, хичээлд тавигдах техник шаардлага:

Багшийн хэрэгцээнд: Зөөврийн болон суурин компьютер, өндөр хурдны интернет сүлжээ, камер, чанга яригч

- ☞ Багш хичээлд хэрэглэх оффис программ ашиглаж хийсэн хялбаршуулсан тайлбар зураг, схем, дүрс зураглал зэрэг суралцагчдад ойлгомжтойгоор хичээлийн сэдвийг бэлтгэсэн байна. Багш өөрөө сургалтад ашиглах үзүүлэн тараах материал бэлтгэнэ. Нэмэлт зурагт хуудас, сонин сэтгүүл, материалыг бэлтгэн цахим орчинд байршуулж болно.

Суралцагчдын хэрэгцээнд: Зөөврийн болон суурин компьютер, сүлжээнд холбогдож болохуйц гар утас байж болно, өндөр хурдны тасалдахгүй интернет сүлжээ, камер, ярих төхөөрөмж, бичиж тэмдэглэх бал, дэвтэр байна.

Сургалтын үр дүн:

Цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалт, мэдээлэл, зөвлөгөө, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ТББ, ААН нь цахим сургалтын горимд шилжсэнээр ХБИ-дэд чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээ тасралтгүй хүртээмжтэй явагдах нөхцөл бололцоо үүсч сургалтын байгууллагууд нэг арга зүйгээр ажиллах боломжтой.

СЭДЭВ 2: Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм-сэтгэл зүйн онцлог, сургалт зохион байгуулахад анхаарах зүйлс

Хичээлийн зорилго: ХБ-тэй хүний онцлог, сургалт зохион байгуулахад анхаарах зүйлсийн тухай мэдлэг ойлголт өгөх

Хичээлийн цаг: 40 минут

Арга зүй: Сэдвийн дагуу PowerPoint илтгэл бэлдэж, хичээлийг тайлбарлах, асуулт, хариулт хэлбэрээр тайлбарлаж зохион байгуулна.

Ашиглах материал: PowerPoint илтгэл, лекц 2

Лекц №2

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм- сэтгэл зүйн онцлог

- ХБ-тэй хүн гэр бүл нийгмийн оролцоо хамааран харилцан адилгүй, зарим тохиолдолд ямар ч чиг баримжаагүй. Суралцагч нэг бүрийн чадавхыг тодорхойлох нь чухал тэд хэзээ суралцаж эхлэхээ тодорхойлогч суралцаж эхлэхээсээ өмнө яагаад үүнд суралцах болсон гэдгээ сайн мэдэж зорилгоо тодорхойлох нь нэн чухал.
- Өөрийн гэсэн үзэл бодолгүй гэж ташаа ойлгож болохгүй. Амьдралын явцад суралцах хүсэл эрмэлзэлтэй болсон байдаг. Сургалтын явц удаан байвал сурах эрмэлзэл нь алга болж, суралцахаас татгалзах явдал их гардаг.
- ХБ-тэй хүн амьдралын зорилго хэрэгцээгээ илүү ухаарсан байдаг тул хурдан сурахыг хүсдэг.
- ХБ-тэй хүн өөрийн сурах арга барилтай. Багш чиглүүлэгч дэмжигчийн зүгээс хүн бүрийн бэрхшээлийн хэлбэрт тохирсон арга барилаар ажиллах, тухайн хүний мэдлэг ур чадвар, хэрэгцээнд тулгуурлан боломжийг нээхэд чиглүүлсэн үйл ажиллагаа явуулах.

Насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд сургалт зохион байгуулахад анхаарах зүйл:

Идэвхтэй оролцоо	✓ ХБ-тэй хүн сургалтын үйл явцад идэвхтэй оролцогч байж чадвал сургалт богино хугацаанд үр дүнтэй байна.Тэд сурсан зүйлээ бодит нөхцөл, амьдрал ахуйдаа хэрэглэх нь чухал байдаг цахим сургалтад багш, суралцагчийн хэрэглэгдэхүүн бүрэн байж “хийх явцдаа суралцах” зарчмаар сургалтыг явуулах
------------------	---

<p>Сургалтын орчин аюулгүй, тайван байх</p>	<ul style="list-style-type: none"> ✓ ХБ–тэй хүн бүх зүйлээ хүнээр заалгаад байх дургүй амар тайван, чөлөөтэй, тэдний үзэл бодол, сонголтыг үнэлж хүртээмжтэй сургалтын орчинг бүрдүүлбэл сургалт амжилттай болно. Байгаа орчиндоо тухай суудал дээр суух, гэр бүлийн туслалцаа шаардлагатай бол авахыг зөвлөх /сурах орчин бүрдүүлэх/
<p>Сургалтын материал ач холбогдол сайтай байх</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Багш сургалтын материал боловсруулахдаа суралцагчдын бэрхшээлийн хэлбэрт тохирсон аргыг сонгох, сургалтын багаж хэрэгсэл тоног төхөөрөмж материалын хэрэгцээг хангахуйц төвшинд бэлтгэхэд анхаарах нь чухал. ✓ Сургалтын материал нь ХБ-тэй насанд хүрсэн хүмүүсийн мэдлэг, туршлагатай холбогдож байвал сургалт үр дүнтэй болно. Суралцагч юу мэддэг, юу чаддагийг урьдчилж мэдэх хэрэгтэй. ✓ Хүн нүдээрээ үзэж, гараараа барьж, сонсож, үнэрлэж, амталж, хийх явцдаа суралцдаг. Хичээлдээ цахим орчноор харуулах хэрэглэгдэхүүнийг болон бодит амьдралын жишээг хэрэглэх
<p>Практик хэрэглээ</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Шинээр олгож буй мэдлэг, чадварыг практикт хэрэглэх боломжтой эсэхийг асууж, практик дээр хэрэглэх зөвлөгөө өгснөөр сургалтын амжилтад сайнаар нөлөөлөх.
<p>Эргэх холбоо</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Эргэх холбоо нь сургалтын явцад ямар дэвшил гарч буйг мэдэхэд тусалдаг сургалтын чухал хэрэгсэлд тооцогддог. <p>Багш суралцагчдын цахим хаялгыг аван Group үүсгэн хоорондоо харилцах, дүгнэлт хичээл дээр багш үнэлгээ хийлгүүлэх</p>

СЭДЭВ 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурах арга барил

Хичээлийн зорилго: ХБ-тэй хүний сурах арга барил, бэрхшээлийн ноцлог давуу талын талаарх мэдлэг ойлголт өгөх

Хичээлийн цаг: 40 минут

Арга зүй: Сэдвийн дагуу PowerPoint илтгэл бэлдэж, хичээлийг тайлбарлах, асуулт, хариулт хэлбэрээр тайлбарлаж зохион байгуулна.

Ашиглах материал: PowerPoint илтгэл, лекц 3

Лекц №3

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурах арга барил:

<p>Насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний сурах арга барил</p>	<p>ХБ хүний сурах арга барил нь суралцагч суралцах үйл явцад мэдлэгийг хүлээж авах бие сэтгэхүйгээ хэрхэн ямар байдлаар ашиглаж буйг хэлнэ.</p> <p><i>Суралцах арга барилыг дараах төрөлд хуваана.</i></p> <ul style="list-style-type: none">✓ <i>Харж суралцагчид</i> Сонсголын бэрхшээлтэй иргэд, сурч буй зүйлээ харахыг илүүд үздэг хүмүүс багтана. Зураг, график диаграмм дүрслэлээс мэдээлэл авах, дагаж хийх нь тэдэнд ямар ч тайлбараас илүү ойлгомжтой байдаг. /Унших/✎ Гарын авлага, сурах бичиг цахимаар илгээх;✎ Тэмдэглэл хийлгэх;✎ Үзүүлэнгийн туслах материал цахимаар өгч ажиллуулах;✎ Дохионы хэлээр харилцах;✎ Дохионы хэлмэрч дэлгэцэд харагдах.✓ <i>Сонсож суралцагчид</i> Сул хараатай, бүрэн хараагүй, сонсохыг илүүд үздэг, сэтгэл зүйн тогтворгүй байдалтай хүмүүс (Сэтгэцийн өвчний зарим төрөл) Тэд ярих дуртай хүмүүс ба уншихаас сонсохыг илүүд үздэг. Энэ төрлийн хүмүүст зориулан дараах аргуудыг хэрэглэх.✎ видеог үзүүлж сонсох;✎ Хэлэлцүүлэг хийх ;✎ Тайлбар, лекц, хийх;
--	---

☞ Дууны өнгө ярианы хурд тохируулах;

☞ Хичээлийн сэдэвтэй холбоотой харилцан яриа, мэтгэлцээн зохион байгуулах

✓ *Хийнгээ суралцагчид* Оюун ухааны хомстол, сэтгэл гутрал, бүрэг, удаан ойлгоцтой, хэл ярианы бэрхшээлтэй, сурах бэрхшээлтэй, бичиг үсэг мэдэхгүй хүмүүс.

☞ Тэд юмыг хийж, биеэрээ туршиж суралцдаг. Энэ төрлийн хүмүүст зориулан дараах аргыг хэрэглэх.

☞ Тэмдэглэл хийлгэх;

☞ Зураг, схем үзүүлэх ижил хэлбэр хэмжээтэй зүйлтэй харьцуулан дүрслэх;

☞ Хийх, ажиллах, турших, гэр бүлтэй нь хамтрах;

☞ Эргэцүүлэн бодох;

☞ Зааварчлах.

Зарим хүмүүс сургалтын үйл ажиллагааны хэлбэр хүн бүрийн бэрхшээлийн хэлбэртэй нийцсэн тохиолдолд тухайн сургалт үр дүнтэй болдог. Гэвч хүн тус бүрийн суралцах хэлбэрт тохируулан сургалтын арга хэлбэрийг хэрэгжүүлэх боломжгүй юм. Багш хичээлдээ сайн бэлтгэж арга барилаа зөв сонгож сонгосон арга барилаа оновчтой ашиглах нь чухал.





2.3 Бэрхшээлийн хэлбэрт тохируулан заах арга зүй

<p>Харааны бэрхшээлтэй хүний сурах арга</p>	<p>Хараагүй, сул хараатай хүмүүс суралцах, хөдөлгөөн хийхдээ ялгаатай байдаг учраас тэдний онцлогт тохирсон аргаар зааж сургах. Хараагүй болон сул хараатай хүнд зориулсан олон төрлийн хэрэгсэл байдаг:</p> <ul style="list-style-type: none"> - Багш шаардлагатай тохиолдолд үзүүлэн тараах материалыг тод, томоор өнгө ялгуулан хэрэглэх - Суралцагч дэлгэц хархаасаа илүүтэй багшийн хэлж буй өгүүлбэрийг хэлж бичих, ойлгох - Брайль үсэгтэй суралцагчаар брайль тэмдэглэгээ хийлгэх - Тод ярьж хоолойн өнгийг тааруулах - Өгүүлбэрүүдийг ойлгомжтой эмх цэгцтэй ярих - Том үсгээр бичсэн хичээл тараах материал цахимаар илгээх - Линз болон томруулагч дэлгэц ашиглах - Аудио бичлэг сонсгох <p><i>Сонсож суралцагчид</i> Сул хараатай, бүрэн хараагүй, сонсохыг илүүд үздэг хүмүүс, сэтгэл зүйн тогтворгүй байдалтай хүмүүс (Сэтгэцийн өвчний зарим төрөл) Тэд ярих дуртай хүмүүс ба уншихаас сонсохыг илүүд үздэг. Сургалтын үед чанга яригчийг багш удирдах</p>
<p>Сонсголын бэрхшээлтэй хүний сурах арга</p>	<ul style="list-style-type: none"> • Сонсголгүй болсон шалтгаан, сонсголын зэрэг, төвшин, төрлүүд хүн бүр өөр байдаг. Жш: нам дууг сонсдог ч чанга дуу хоолойг сонсдоггүй, нам дууг сонсдоггүй чанга дууг сонсдог, бүүр сонсголгүй • Сонсох чадвараас хүний хэл яриа эзэмших, хүний ерөнхий хөгжилд ихээхэн нөлөөтэй байдаг сонсох чадварт нь тохирсон сургалтын арга зүй хэрэглэх нь чухал. • Сонсголгүй хүнд боловсрол олгох ерөнхий, дэлхий нийтээр дэлгэрсэн гурван арга зүй байдаг • Аман хэлний арга зүй (амны хайрцгаар унших) • Хавсарсан хэлний арга зүй (амны хайрцгаас болон уруулаас унших)

- Хос хэл, соёлын арга зүй (Дохионы хэлтэй бичгийн хэлийг хослуулах)

Хүний амны хөдөлгөөнийг хараад юу ярьж байгааг ойлгож сурахыг манай согог зүйчид “Амны хайрцгаас уншуулах” болон “уруулаас унших”-ыг хэлнэ. Энэ сул сонсголтой хүмүүст үр дүнтэй

- Хавсарсан хэлний арга зүй

Аман хэлний өгүүлбэрийн байгуулалтаар зохион үг нэг бүрийг дохиогоор илэрхийлэхийн хажуугаар амаараа давхар ярих үйл ажиллагаа юм.

- Хос хэл, соёлын арга зүй

Хос хэл соёлын арга зүйн үндэс нь дохионы хэл болно. Хос хэл соёл гэдэг нь тухай улсын дохионы хэлийг бичгийн хэлтэй хослуулан сурах. Сонсголгүй иргэд нь нэгэнт сонсголтой иргэдтэй хамт нэг нийгэмд амьдарч байгаа учир тэд тухай улсынхаа бичгийн хэлийг эх дохионы хэлтэйгээ хослуулан хэрэглэдэг тул тэд нийгмийн шаардлагаар хос хэлтэй байх шаардлагатай байдаг.

Сонсголын бэрхшээлтэй суралцагчид хос хэл соёлын сургалтын орчин бүрдүүлэх

- FM систем: сул сонсголтой суралцагчдад багшийн яриаг сонсох боломжтой
- Гэрлэн хонх: Анги танхим хаалганд гэрэлт хонх байрлуулах дуут дохионоос гэрэл асаж мэдэгддэгээрээ ялгаатай хаалга тогших хонох дарахад сонсож хүлээн авах боломжгүй тул тэд хараагаараа хүлээн авч болохоор зохицуулна
- Гэрэл дохиолол: Анги танхим, хаалганд гэрэл дохиолол байрлуулж хичээлийн цаг, завсарлаг болон янз бүрийн онцгой байдалд шуурхай дохиолол өгөх
- Камер: Камерт бичигдсэн хичээлийг нөхөн үзэх хичээлээ давтахад сэргээхэд хэрэглэнэ.
- Зурагт үзүүлэн: Сонсголгүй хүмүүс зурагт бодит үзүүлэнгүүд нь юмыг ойлгох, хүлээн авахад илүү хялбар

Хараагаар хүлээн авах орчин бүрдүүлэх:

- Багш амны хайрцаг сайтай байх
- Камертайгаа ойртон тулж ярих
- Хичээлийн завсарлага бусад онцгой байдлыг дохиог зургаар илэрхийлдэг байх

	<ul style="list-style-type: none"> • Үзүүлэн тараах материалыг аль болох өнгөт байлгах • Хичээлийг бодитоор хамтран хийж үзүүлэх • Багш дохионы хэлтэй байх, эсвэл заавал дохионы орчуулагчтай байх
<p>Оюун ухааны бэрхшээлтэй хүний сурах арга барил</p>	<p>Оюун ухааны бэрхшээлийн хэв шинж:</p> <p>Оюун ухааны бэрхшээлтэй хүн хоорондоо адилгүй, бараг анзаарагдахгүй хөнгөн хэлбэрийн нэгэн байхад огт үйлдэл хийх чадваргүй хүнд хэлбэрийн нэгэн ч байдаг.</p> <p>Оюун ухааны бэрхшээлийг хэв шинжээр нь дараах 2 бүлэгт хуваана:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Оюун ухааны чадварын алдагдал ✓ Дасан зохицох чадварын алдагдал <p>Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүнд хоёр хэв шинж хоёулаа эсвэл нэг нь илэрч болно.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Оюун ухааны чадварыг сорилоор тодорхойлох үнэлгээ: <p>Оюун ухааны чадварыг сорилоор тодорхойлох үнэлгээ нь нэг бус хэд хэдэн төрөл байдаг.</p> <p>Оюун ухааны чадвар алдагдлыг IQ үнэлгээгээр дараах 4 түвшинд авч үздэг.</p> <p>Оюун ухааны чадвар алдалтын онцлог шинж</p> <ul style="list-style-type: none"> ❖ Оюуны хөнгөн хэлбэр IQ 50-70 <ul style="list-style-type: none"> - Юмс үзэгдлийн талаар тодорхой хэмжээний ойлголттой - Эргэцүүлэн бодох чадвартай - Хийсвэр сэтгэхүй сул боловч энгийн хийсвэрлэн сэтгэх чадвартай - Механик цээжлэх ой сайн - Юмны учир зүйн холбоо, агуулга, чанарыг дутуу ойлгодог - Далд утгатай үг, тооны болон ШУ ны нэр томъёог сул эзэмшсэн - Өдөр тутмын хэрэглээний үг, ойлголт, үзэгдэл юмсын холбоог ойлгоно - Нийгмийн дасан зохицолд харьцангуй сайн

- Бие даан амьдрах чадвартай
 - Бага боловсрол, энгийн хөнгөн мэргэжил эзэмших чадвартай.
- ❖ Хүндэвтэр хэлбэр: IQ 35-49
- Үгийн нөөц маш хязгаарлагдмал
 - Өдөр тутмын маш энгийн яриатай
 - Бие даах, өөртөө үйлчлэх чадвар сул
 - Ойр зуурын хэрэгцээний механик ойтой
 - Юмс үзэгдлийн зүй тогтол, харьцуулалт хангахгүй
 - Хийсвэр ухагдахуун эзэмших чадвар
 - Ухаарч танин мэдэх чадвар сул
 - Сэтгэлийн хөдөлгөөн тогтворгүй
 - Хийсвэр ухагдахуун эзэмших чадвар сул
- ✓ Хүнд хэлбэр: IQ 20-34
- Үг хэлээр харилцах чадваргүй
 - Хүний яриаг огт ойлгохгүй
 - Маш энгийн дохио зангаа, тэмдэг ашиглана
 - Ихэвчлэн бусад ХБ-тэй хавсарсан байдаг.
- ✓ Гүнзгий хэлбэр: IQ 20-с бага
- Гүнзгий хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүн маш цөөхөн тохиолддог тэдний 1-2 хувийг эзэлдэг. Гүнзгий хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүн бусдын асаргаанд байна.
- ✓ Оюун ухааны бэрхшээлтэй хүнтэй ажиллах
- Дотнын хүн болох: Оюун ухааны бэрхшээлтэй гэдгээр тусгайлан харьцаж, онцгойлон авч үзэх шаардлагагүй. Энгийнээр харьцаж, бусдаас дутуу, онцгой биш гэдгийг ойлгуулах.
- ✓ Дургүй болсон зүйлээ хийдэггүй
- Хэн ч дургүй зүйлээ хийхийг хүсдэггүй. Оюун ухааны бэрхшээлтэй хүний хувьд ч мөн адил.
- ✓ Төвөг болж байна уу, үгүй юу гэдгийг сайтар ажиглах
- Оюун ухааны бэрхшээлтэй хүнтэй ажиллах болон тусламж дэмжлэг үзүүлэх үед “Оюун ухааны бэрхшээлтэй учраас юу ч чадахгүй” гэсэн байдлаар хандахаас аль болох зайлсхийх. Бэрхшээлтэй байгаа зүйлд нь бага зэргийн эсвэл зөвхөн шаардлагатай дохиололд тусал

	<ul style="list-style-type: none"> ✓ Чадаж буй зүйлийг нь урамшуулан дэмжих ✓ Чөлөөтэй ярилцах
Хөдөлгөөний бэрхшээлтэй хүний сурах арга барил	<ul style="list-style-type: none"> • Хөдөлгөөний бэрхшээлтэй хүн тогтвор суурьшилтай суух анхаарлаа төвлүүлэх нь бусдаас илүү цахимаар сургалт явуулахад хялбар байдаг. • Хүртээмжтэй орчинг бүрдүүлэх: Тухтай эвтэйхэн байрлалд суух зөвлөгөө өгөх

СЭДЭВ 4: Цахим хичээлд тавигдах технологийн шаардлага

Хичээлийн зорилго: Цахим хичээл явуулах шаардлагатай техник технологийн мэдлэг олгох

Хичээлийн цаг: 1 цаг академик цагаар

Арга зүй: Сэдвийн дагуу PowerPoint илтгэл бэлдэж, хичээлийг тайлбарлах, бодит үзүүлэнг бэлдэх асуулт, хариулт хэлбэрээр тайлбарлаж зохион байгуулна.

Ашиглах материал: PowerPoint илтгэл, лекц 2, цахим хичээлд хэрэглэгдэх хэрэглэгдэхүүний бодит болон зуран үзүүлэн

ЛЕКЦ: 4

1. Цахим сургалтад шаардагдах техник, технологи	<ul style="list-style-type: none"> ✚ Багшид: <ul style="list-style-type: none"> ✓ Computer/notebook ✓ Дагалдах хэрэгслүүд /speaker, web camera/ ✓ Internet ✚ Сурагчид: <ul style="list-style-type: none"> ✓ Smartphone/Tablet/Computer/Notebook ✓ Дагалдах хэрэгслүүд /speaker, web camera/ ✓ Internet
2. Хичээл бэлдэх ерөнхий арга зүй	
Цахим хичээлд тавигдах ерөнхий шаардлага	<ul style="list-style-type: none"> ✓ Цахим хичээлд оюуны өмчийн болон зохиогчийн эрхийн зөрчилгүй байна ✓ Цахим хичээлд дүрс бичлэг зурагт лого болон бүх эрхийг хуулиар хамгаалагдсан зүүлт болон оюуны өмчийн санамж байршуулсан байна. ✓ Цахим сургалтын хэлбэрээс хамааруулан тоног төхөөрөмж болон программ хангамжтай хэрхэн харилцах, цахим сургалтын үеийн орчин нөхцөлийн тухай анхан шатны мэдлэгтэй байх. ✓ Microsoft office программын анхан шатны мэдлэгтэй байна. ✓ Нэг сэдвийн агуулга тус тусдаа нэг ойлголтыг агуулсан хэд хэдэн дүрс бичлэгээс тогтож болох бөгөөд нэгж бичлэгийн хугацаа 10 минутаас хэтрэхгүй байна.

	<ul style="list-style-type: none"> ✓ Дэвсгэр өнгө болон үзүүлэнгийн суурь өнгө нь цайвар өнгөтэй, олон төрлийн дүрс бичиггүй байна. ✓ Үзүүлэнгийн текст хар бараан өнгөтэй байна ✓ Дүрс бичлэгийн нарийвчлал 720P ба түүнээс багагүй байх бөгөөд харьцаа нь 16:9 байна. ✓ Дүрс бичлэг нь кодек H.264 байх ба дууны кодек нь AAC байна. ✓ Дүрс бичлэг нь MP4 форматтай байна. ✓ Орчны дуу чимээ багатай байна ✓ Ярианы дууны төвшин хэт нам, хэт чанга биш тохиромжтой байна. ✓ Дохионы хэлмэрчтэй бол дэлгэцийн 3:1 хэмжээнд дүрс байрласан байна
<p>Цахим хичээлд тавигдах техник тоног төхөөрөмжийн шаардлага</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Computer - Зөөврийн болон суурин компьютер гацалт багатай I3-н 1-р үе болон түүнээс дээш байна. ✓ Internet - Цахилгаан болон интернетийн сааталгүй байна. Интернет UpLoad speed – 3 Mbps, Download speed – 6 Mbps доошгүй байна ✓ Monitor - 19 инч болон түүнээс дээш хэмжээтэй дэлгэцтэй байна. ✓ Camera - 720P нягтарталтай микрофонтой веб камер эсвэл түүнтэй дүйцэхүйц байна. ✓ Speaker - Чанга яригч /speaker/ эсвэл микрофонтой чихэвчтэй байна ✓ Mobile phone - Гар утас нь ухаалаг утас байна
<p>Цахим хичээлд программын шаардлага</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Компьютерийн анхан шатны мэдлэгтэй байх ✓ Microsoft office буюу word excel powerpoint гэх мэт хэрэглээний анхан шатны мэдлэгтэй байх ✓ Google apps анхан шатны мэдлэгтэй байх ✓ И-мэйл хаяг нээсэн байх

СЭДЭВ 5: Цахим сургалтын програмууд

Хичээлийн зорилго: Цахим хичээл явуулхад шаардалгатай цахим програмуудын талаарх мэдэг олгох

Хичээлийн цаг: 9 цаг академик цагаар

Арга зүй: Сэдвийн дагуу PowerPoint илтгэл бэлдэж, хичээлийг тайлбарлах, асуулт, хариулт хэлбэрээр тайлбарлаж зохион байгуулна. Цахим хуудсуудаар нэвтрэн бодит үйлдлээр харуулж суралцагчид даган дуурайх практик дадлага хийлгэх, дасгал, даалгавар өгнө.

Ашиглах материал: PowerPoint илтгэл, лекц 2, цахим платформууд, зурган болон бодит үзүүлэн, тараах материал цахим хэлбэрээр

Лекц №5

Zoom ашиглан сургалт явуулах	Google meet, google from текст боловсруулах ашиглан сургалт явуулах	Teams програм ашиглан сургалт явуулах
<ul style="list-style-type: none"> • Үнэгүй бүртгүүлж орно • Бүх төрлийн төхөөрөмж дэмжинэ • 100 хүртэлх хүнд үнэгүй хэрэглэж болно. Дээд тал нь 500 хүн орж болно • 49 хүртэлх хүн Screenshare хийх боломжтой • Оролцогчид нь хурал цуглааны үеэр тусдаа жижиг өрөө нээж хуралдах боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Файлаа чатаар явуулах боломжтой • Google apps-г бүрэн дэмждэг • 250 хүн хүртэл үнэгүй хэрэглэж болно. Дээд тал нь • Хоорондоо аудио дуудлага үнэгүй • Бүх төрлийн төхөөрөмж дэмжинэ. • Хүлээлгийн өрөө байдаггүй • 1 хүн screenshare хийх боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Office 365 программыг бүрэн дэмждэг • Онлайнд бичлэгээ хадгалах боломжтой байдаг • Үнэгүй чатлах боломжтой • Бүх төрлийн төхөөрөмж дэмжинэ. • Хажуу талын цэсээс мэдээллээ хайхад хялбар

<ul style="list-style-type: none"> • Аппликешн татаж ашигладаг • 40минут нь үнэгүй ашиглах боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Онлайнд бичлэгээ хадгалах боломжтой байдаг • 15 гб хэмжээ хүртэлх мэдээлэл хадгалж болно. 	<ul style="list-style-type: none"> • Хязгааргүй дуудлага • Хүлээлгийн өрөө байдаггүй
--	--	--

Вэбинар гэж юу вэ? Вэбинар, эсвэл вэб-төгссөн семинар, нь видео хурлын програм хангамжаар дамжуулан интернетээр дамжуулж танилцуулга, лекц, семинар, семинар юм. Вэбинарын гол онцлог нь интерактив юм. Вебинарын танилцуулгад оролцогчид мэдээллийг бодит цаг хугацаанд дамжуулах, хүлээн авах, хэлэлцэх чадвартай байдаг.

Хамгийн алдартай вэбинар програм хангамжийн дунд та олох болно Zoom, Microsoft-ын багууд болон Skype. Энэхүү вебинар програмыг ашиглан илтгэгчид үг хэлэх үеэрээ видео, баримт бичиг, програмаа вебинарт оролцогчидтой хуваалцах боломжтой. Өнөө үед олон вэбинарын үйлчилгээнүүд шууд дамжуулалтын сонголтууд эсвэл вэбинаруудаа бүртгүүлж, Youtube дээр нийтлэх боломжийг санал болгодог. Олон улсад видео хурал, онлайн хичээл болон өдөр тутамд хэрэглэгддэг хэд зуун программ хангамж байдгаас Монгол улсад дараах гурван программыг түлхүү ашиглаж байна. Дараах программууд нь хэрэглэхэд хялбар нууцлал өндөртэй.

Сургалтын үед бичлэг хэрхэн хийх вэ?

Та аль ч программыг сонгосон ялгаагүй бүх вебинарууд дээр бичлэг /Record/ хийж хадгалах боломжтой байдаг. Бичлэг хийхдээ та программаа нээгээд record гэсэн товчлуур дээр дарж бичлэг хийнэ. Хэрэв зохион байгуулагч биш оролцогч тал бол мөн адил Record гэсэн товчлуур дээр дараад request record буюу зохион байгуулагчаас бичлэг хийх зөвшөөрөл хүснэ. Админ зөвшөөрсөн тохиолдолд бичлэг хийгдэнэ. Бичлэг хийхдээ хаана хадгалах замаа зааж өгнө. Вебинар дуусаад End meeting дархаар бичлэг автоматаар хадгалагдана.

Any desk ашиглах заавар ойлголт	Anydesk программ хангамж нь 1 компьютерээс нөгөө компьютерийг алсын зайнаас удирдах боломж олгодог ба	Өөр өөр платформд зориулсан AnyDesk-ийн бүх сонголтыг албан ёсны вэбсайтаас
---------------------------------	---	---

	<p>удирдаж буй үйлдлийг бичлэг болгон хадгалах, файл дамжуулах, хоорондоо ярилцах чат бичих зэрэг үйлдлүүдийг хийж болно. TeamViewer программ нь мөн адил үүрэг зориулалттай. Татаж авах болон хэрхэн ашиглах зааврыг дараах холбоосоос үзнэ үү.</p> <p>татах холбоос: https://www.teamviewer.com/en/download/windows/</p> <p>заавар үзэх холбоос: https://www.youtube.com/watch?v=y4oh_4eLTZE</p>	<p>//anydesk.com/ru/ татаж авч болно (гар утасны төхөөрөмж дээр та Play Store эсвэл Apple App Store-ийг шууд ашиглаж болно). Windows-т зориулагдсан AnyDesk-ийн хувилбар нь компьютер дээр заавал суулгахыг шаарддаггүй (гэхдээ програм хаагдах бүрт үүнийг ажиллуулахыг санал болгоно), зүгээр л эхлүүлээд үүнийг ашиглаж эхэлнэ үү</p>
--	--	--

Сургалтад оролцогчдыг үнэлэх хуудас

Тухайн сургалтын ойлголт, мэдлэгийг бататгах зорилгоор цахим орчинд хэлэлцүүлэг, хяналтын асуулт гэх мэт аргуудын ашиглаж болно.

Давтан сурах шаардлагатай эсэх:

- ❖ Сургалтын үр дүнд хүрэх явцад суралцагчдын мэдлэг, чадвар ямар төвшинд байгааг тодорхойлох;
- ❖ Хичээлийн зорилгод хүрсэн эсэхийг үнэлнэ.

Үнэлгээний хуудас:

Та үнэлгээг 1-5 түвшинд өгсүүлэх байдлаар үнэлнэ үү.

№	Асуулт	Тайлбар	Үнэлгээ
1	Та өөрийн хүсэн мэдлэгээ олж авсан эсэх		1 2 3 4 5
2	Та сургалтаас шинэ мэдлэгүүдийг олж авч чадсан эсэх		1 2 3 4 5
3	Та ямар сэдвийг илүү ойлголгосон бэ?		
4	Шинээр авахыг хүсч буй мэдлэг		
5	Та энэхүү сургалтын талаарх сэтгэгдлээ үлдээнэ үү?		1 2 3 4 5
6	Хэн багш илүү сайн ойлгомжтой заасан бэ?		

Эх сурвалж:

1. ... (2018). Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан эрх зүйн мэдлэг олгох сургалтын хөтөлбөр, Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Д.Одгэрэл, Б.Намираа (2018). Тусгай боловсрол онцлог бүхий суралцагчдыг дэмжих онол, арга зүй. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Google платформ
 - <https://mn.eyewater.com/>
 - <https://anydesk.com/en>
 - <https://docs.google.com/>